



ХАСБАНК ХК-ИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025 ОНЫ 3-Р САРЫН 31-НИЙ БАЙДЛААР



Агуулга

- | | |
|---|-------|
| 1. Онцлох үйл явдал | 3 |
| 2. Санхүүгийн үзүүлэлтүүд | 4-9 |
| 3. Монголбанкнаас тогтоосон зохистой
харьцааны шалгуур үзүүлэлтүүд | 10-11 |
| 4. Компанийн засаглал | 12 |

Онцлох үйл явдал

147 сая ам.долларын синдикат зээлийн гэрээ байгуулав




ХасБанк Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ)-тай 147 сая ам.долларын синдикат зээлийн гэрээнд гарын үсэг зурж ЕСБХБ-аас Монгол Улсын банкны салбарт хийж буй хамгийн өндөр дүнтэй санхүүжилт боллоо. Оролцогчоор Allianz Global Investors, FMO, ILX, Германы AKA Банк болон Invest in Visions гэсэн байгууллагууд оролцжээ.

“Асуудалгүй” үйлчилгээг амжилттай танилцууллаа



ХасБанк “Асуудалгүй” үйлчилгээг зах зээлд амжилттай нэвтрүүлж нийт хэрэглэгчийн тоо өмнөх улирлаас 358.1% өсч 31.9 мянга боллоо. “Асуудалгүй” үйлчилгээний хэрэглэгчид 400 мянга төгрөг хүртэл дүнгээр өөрийн харилцах данснаас зарлага гаргах боломжтой.

Урамшуулалт аяны үр дүнд хадгаламжийн хэмжээ өслөө




2025 оны I улииралд ХасБанк тогтмол хуримтлуулж, тогтвортой өсгөж буй харилцагчдаа шагнахаар нэг тэрбум төгрөгийн шагналын сантай хадгаламжийн аян зарлалаа. Тус аяны үр дүнд нийт хугацаатай хадгаламжийн дүн 4.4 хувиар өсөж 2,674 тэрбум төгрөг болов.

Bank of New York Mellon банкинд данс нээлтээ



ХасБанк АНУ-ын Нью-Йорк Меллон Банк (BNY Mellon)-тай корреспондент харилцаа тогтоож, ам.долларын данс нээлтээ. Ингэснээр олон улсад чиглэсэн ам.долларын гүйлгээг урьд өмнөхөөс илүү хурдан, найдвартай, бага зардлаар хийх боломж бүрдэж байгаагаас гадна SWIFT-ээр дамжуулан гадаадаас ам.долларын шилжүүлэг хүлээн авах хугацааг 2-3 дахин богиносгох давуу талтай.

27.0 төгрөгийн ногдол ашиг тараах шийдвэр гаргалаа



ХасБанк ХК (“Банк”)-ийн жилийн эцсийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 27.0 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд жилийн эцсийн ногдол ашиг болгон хуваарилахаар шийдвэрлэлээ. Ингэснээр 2024 оны нийт цэвэр ашгаас нэгж хувьцаанд 45.0 төгрөгийн ашигийг тараахаар боллоо.

ХасЛизинг шинэ харилцагчийн төв нээлтээ



ХасЛизинг шинэ салбараа UG arena-д нээж харилцагчдадаа улам ойртсоор байна. UG Arena дахь шинээр нээгдсэн лизингийн төвөөр үйлчлүүлснээр харилцагчид импортын авто машин худалдан аваадаа өөрт ойр, шуурхай, уян хатан нөхцлөөр ХасЛизингийн үйлчилгээг авах боломжтой.

Санхүүгийн үр дүн



2025 оны I улирал

Цэвэр ашиг	ROE	ХАС (Хувьцааны ханш)	EPS	1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа
₮44.1 тэрбум	23.4%	₮854.0	₮167.7*	19.6% >12.5%	36.7% >25.0%

Ашигт ажиллагаа

- 2025 оны I улиралд ХасБанкны татварын дараах цэвэр ашиг 44.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх улирлаас 2.8% хувь өслөө. Тайлант хугацаанд Банкны зээлийн багцийн өсөлт болон үр ашигтай эрсдлийн удирдлагын бодлого хэрэгжүүлснээр ашигт ажиллагаа нэмэгдсэн байна.
- 2025 оны I улирлын байдлаар өөрийн хөрөнгийн өгөөж буюу ROE 23.4%, улирлын нэгж хувьцаанд ногдох ашиг буюу EPS 41.9 төгрөг бол жилд шилжүүлж тооцвол 167.7 төгрөг байна.

Баланс

- Нийт зээлийн багц өмнөх улирлаас 4.0 хувь өсөж 3,846 тэрбум төгрөгт хүрлээ.
- Иргэдийн банкны зээлийн багц 5.0 хувиар өсөж 2,717 тэрбум төгрөгт хүрэхэд хэрэглээний болон бичил, ЖДБ зээлийн өсөлт нөлөөлжээ.
- Харилцагч байгууллагууд болон шинэ харилцагчийн төвийн үйл ажиллагааны үр дүнд санхүүгийн түрээсийн багц 8.8 хувиар өсөж 508 тэрбум төгрөгт хүрлээ.
- Чанаргүй зээлийн харьцаа 2.1% болж өмнөх улирлаас 0.1 хувиар өссөн байна.
- Нийт харилцах, хадгаламжийн хэмжээ өмнөх улирлаас 1.7 хувиар буурч 3,366 тэрбум төгрөгт, гадаад эх үүсвэрийн хэмжээ 9.7 хувиар өсөж 493 сая ам.долларт тус тус хүрлээ.

Харьцаа үзүүлэлт

- 2025 оны I улирлын байдлаар Монголбанкнаас тогтоосон харьцааны шалгуур үзүүлэлтүүд зохистой хэмжээнд байна.
- 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 19.6% буюу доод хэмжээг 7.1%-иар давуулан биелүүлсэн байна.
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 2025 оны 3 сарын 31-ний байдлаар 36.7% байгаа нь зохистой харьцааг хангаж байна.

* Жилд шилжүүлсэн нэгж хувьцаанд ногдох ашиг




Санхүүгийн үзүүлэлтийн тренд

| 2025 оны I улирал


Цэвэр ашиг

Тэрбум төгрөг




Нийт актив

Тэрбум төгрөг




Зээлийн багц

Тэрбум төгрөг



Өөрийн хөрөнгийн өгөөж

Сүүлийн 12 сарын дундаж өөрийн хөрөнгөөр тооцов.



1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа





Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа



Зээлийн үйл ажиллагаа

| 2025 оны I улирал

Нийт зээлийн тоо	Иргэдийн банк зээлийн тоо	Байгууллагын банк зээлийн тоо	ХасЛизинг с.түрээсийн тоо	Онлайн зээлийн тоо
215.1 мянга ▲ 14.4% QoQ	210.5 мянга	0.2 мянга	4.4 мянга	143.3 мянга ▲ 21.2% QoQ



- 2025 оны I улиралд зээлийн багц 4.0 хувь өсөж 3,846 тэрбум төгрөгт хүрлээ. Энэхүү өсөлтөд бичил жижиг бизнесийн зээл, хэрэглээний зээл болон санхүүгийн түрээсийн багцын өсөлт голчлон нөлөөлжээ.
- Шинээр нэвтрүүлсэн “Асуудалгүй” үйлчилгээний хэрэглэгчид өмнөх улирлаас 22.3 мянгаар өссөн байна.


Дотоод эх үүсвэр

| 2025 оны I улирал

Нийт дансны тоо	Харилцах дансны тоо	Хадгаламжийн дансны тоо	“Асуудалгүй” үйчилгээний хэрэглэгчийн тоо
1.4 сая ▲ 3.1% QoQ	885.5 мянга	545.1 мянга	36.3 мянга ▲ 353.7% QoQ


Харилцах, хадгаламж

Тэрбум төгрөг



Бүтээгдэхүүний төрлөөр

Тэрбум төгрөг



- 2025 оны I улиралд ХасБанкны харилцах дансны үлдэгдэл 670-850 тэрбум төгрөгийн хооронд байсан нь бизнесийн идэвхжилийн үе буюу улирлын нөлөөлөлтэй холбоотой.
- Нийт хадгаламж өмнөх улирлаас 4.4 хувиар өсөж 2,674 тэрбум төгрөг болсон нь хадгаламжийн өсөлтийг дэмжих аян зохион байгуулж буй нь голчлон нөлөөлсөн байна.


Гадаад эх үүсвэр

| 2025 оны I улирал

2025 оны I улиралд Азийн хөгжлийн банк (АХБ)-тай хийсэн 50 сая ам.долларын гэрээний дагуу эх үүсвэрийг Бичил, ЖДБ болон байгальд ээлтэй ногоон төслүүдийг дэмжих зорилготойгоор татан төвлөрүүллээ. Мөн түүнчлэн ХасБанк 35 хүртэлх насын залуу бизнес эрхлэгчдийг дэмжих зорилготойгоор Европын сэргээн босголт хөгжлийн банк (ЕСБХБ)-тай 147 сая ам.долларын синдикат зээлийн гэрээг амжилттай байгууллаа. Тус синдикат санхүүжилтэд Allianz Global Investors, FMO, ILX, Германы AKA Банк болон Invest in Visions гэсэн олон улсын санхүүгийн байгууллага болон сангүүд оролцсон байна.

Гадаад эх үүсвэрийн үлдэгдэл

Сая ам.доллар



Шинэ эх үүсвэрүүд



\$50,000,000

Бичил, ЖДБ болон ногоон эдийн засгийг дэмжих зориулалтаар татан төвлөрүүллээ



\$147,000,000

35 хүртэлх насын залуу бизнес эрхлэгчдэд зориулсан синдикат зээлийн гэрээнд гарын үсэг зурлаа.

Хувьцааны мэдээлэл

2025 оны I улирал

ХасБанк ХК (ХАС)-ын хувьцааны үнэ 2025 оны 3 сарын 31-нд 854.06 төгрөгөөр хаагдсан нь он гарснаар 3.4 хувь өссөн үзүүлэлт буюу IPO хийсэн үнээс 26.2% өссөн үзүүлэлт болсон байна. 2025 оны I улирлын байдлаар нэгж хувьцаанд ногдох цэвэр ашиг 41.6 төгрөг, жилд шилжүүлбэл 167.7 төгрөг байна.

ХасБанк 2024 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 18.0 төгрөгийн ногдол ашиг тараасан. Харин 2024 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас Банкны төлөөлөн удирдах зөвлөл нэгж хувьцаанд 27.0 төгрөг буюу 28.4 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараах шийдвэр гаргасан. Ингэснээр 2024 оны нийт цэвэр ашгаас нэгж хувьцаанд 45.0 төгрөг буюу 47.3 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараах бөгөөд тус шийдвэрийг Монголбанкнаас зөвшөөрч, Банкны дүрмийн дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн баталсны дараа хуваарилна.


ХАС хувьцааны ханш, арилжааны хэмжээ



Ногдол ашиг хуваарилалт

Тэрбум төгрөг

2024 оны эхний хагас жилийн ногдол ашиг нэгж хувьцаанд **18.0**
2024 оны сүүлийн хагас жилийн ногдол ашиг нэгж хувьцаанд **27.0**



*Тус шийдвэрийг Монголбанкнаас зөвшөөрч, Банкны Дүрмийн дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн баталсны дараагаар ногдол ашгийг тараах юм




Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

| 2025 оны I улирал

1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа

19.6% Байвал зохих доод хэмжээ 12.5%




Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа

36.7% Байвал зохих доод хэмжээ 25.0%

Түргэн борлогдох актив

Нийт **1,980.7** тэрбум төгрөг



Монголбанкнаас тогтоосон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

	2024 I улирал	2024 II улирал	2024 III улирал	2024 IV улирал	2025 I улирал
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар) +/-15%	-1.9%	-2.3%	-6.2%	-1.7%	-2.0%
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт валютаар) +/-30%	-2.9%	-3.3%	-9.1%	-2.0%	-3.3%
Нийт томоохон зээлдэгчдэд олгох активын төвлөрлийн харьцаа <300%	33.0%	52.9%	56.9%	41.7%	51.7%
Үндсэн хөрөнгө нийт хөрөнгийн харьцаа <8%	1.4%	1.2%	1.2%	1.2%	1.2%
Хадгаламжийн төвлөрлийн харьцаа <25%	7.8%	7.9%	7.4%	7.9%	7.0%

	2024 I улирал	2024 II улирал	2024 III улирал	2024 IV улирал	2025 I улирал
Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй):					

Банкны хувьцаа эзэмшигчид	0.9%	0.7%	1.7%	2.2%	1.7%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.1%	0.1%	0.1%	0.1%	0.1%
Банкны бусад холбогдох этгээд	3.0%	2.9%	2.8%	0.0%	0.0%

Банкны хувьцаа эзэмшигчид	0.9%	0.7%	1.7%	2.3%	1.8%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.3%	0.5%	0.4%	0.3%	0.3%
Банкны бусад холбогдох этгээд	3.0%	2.9%	2.8%	0.1%	0.0%



Төлөөлөн удирдах зөвлөлийн болон ТУЗ-ийн дэргэдэх хорооны хурал

| 2025 оны | улирал

3

ТУЗ-ийн хурал

2

ТУЗ-ийн цахим
санал хураалт

18

ТУЗ-ийн тогтоол



Засаглал, нэр дэвшүүлэх,
цалин урамшууллын хороо

1 удаагийн хурал, 1 удаагийн
цахим санал хураалт



Эрсдэлийн
удирдлагын хороо

1 удаагийн хурал, 1
удаагийн цахим санал
хураалт



Аудитын
хороо

1 удаагийн хурал



Санхүүгийн зохицуулах хороо ("СЗХ")-ноос баталсан **"КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС"-ийн удирдамжийн үнэлгээний аргачлалын дагуу ХасБанкны "Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт"-ийн 2024 оны тайланг СЗХ-ноос хянан баталгаажуулж **93.1%** буюу **засаглал сайн, эрсдэлгүй** гэж үнэлэв.**



📞 (976)-75771888-(888)

✉ InvestorRelations@xacbank.mn

🌐 <https://www.xacbank.mn>